

2014 оны нүүрсний зах зээлийн тойм

Д. Долгорсүрэн, Удирдлагын Академийн дэд профессор, эдийн засгийн ухааны доктор

Огноо: 2015 оны 1 дугээр сарын 12

Хураангуй: Коксжих нүүрсний зах зээл дээр нийлүүлэлтийн илүүдэл үүссэн, нөгөөтэйгүүр Хятадын нүүрсний импортын эрэлт буурсан учир коксжих нүүрсний үнэ тасралтгүй буурав. Хятадын засгийн газар дотоодын нүүрсний салбарыг бодлогоор дэмжих олон арга хэмжээ авсан жил болов. Үр ашиггүй уурхайнууд хаагдан нүүрсний илүүдэл арилах мөн Хятадын эрэлт сэргэх цагт үнэ тогтворжино.

Хятадын нүүрсний салбарын бодлого 2014 онд

Хятадын импортын коксжих нүүрсний спот үнэ 2014 онд харьцангуй тогтвортой байсан ч Хятадын засгийн газар дотоодын нүүрсний салбарыг дэмжих олон төрлийн бодлогын арга хэмжээ авсан жил байлаа.

Хятадын Шанси мужид төмөр замаар ачихад бэлэн болсон сайн чанарын хатуу коксжих нүүрсний үнэ оны эхнээс 24 хувь буурч 137 ам. доллар болж нүүрс олборлогчийн тонн тутмаас олох орлого 2014 оны эхний гурван улиралд 40 цент бол тус үзүүлэлт 2013 онд 7 доллар, 2011 онд 23 ам.доллар байсан. Ийнхүү нүүрсний үнэ буурсан явдал дотоодын компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж зарим уурхай хаагдан ажилгүйдэл ихээр үүссэнд Хятадын засгийн газраас анхаарал тавьж байсан нь ажилгүйдлийг бууруулахаас илүүтэй тус компаниудын өрийн асуудалтай холбоотой байжээ. Учир нь нүүрсний салбарт их хэмжээний өр авлага үүссэн тул дотоодын нүүрсний зах зээлээ аврах гэж Хятадын засгийн газар дараах дөрвөн төрлийн бодлогын өөрчлөлт хийсэн байна.

Импортын татвар

Хятад 2014 оны 10-р сард нүүрсний импортын татварыг коксжих нүүрс болон антрацит хоёрт 3 хувь, эрчим хүчний нүүрс болон коксжих нүүрснээс бусад чулуун нүүрсэнд 5-6 хувь байхаар тогтоосон бөгөөд энэхүү арга хэмжээний тухайд урьдчилан мэдэгдээгүй бөгөөд татвар авахыг зарласан өдрөөс зургаан хоногийн

дараа хууль хүчин төгөлдөр болж эхэлсэн байна. Энэхүү бодлогын арга хэмжээний дүнд дотоодын олборлогчид нүүрсний үнээ 2-3 ам. доллараар шууд нэмэхэд хүргэжээ.

10-р сарын 15-нд импортын татварын хууль хэрэгжиж эхэлсэнээс хойши нүүрсний үнэ хоёр сарын хугацаанд харьцангуй тогтвортой байсан бөгөөд Steel First мэдээгээр Хятадын зүүн эрэгт хүрсэн сайн чанарын хатуу коксжих нүүрсний үнэ 12-р сарын 12-нд 121.10 ам. доллар байсан бол импортын татвартай болно гэж зарлах өдрөөс өмнө 10-р сарын 8-нд тус үзүүлэлт 122.29 ам. доллар байжээ. Үнэ тогтвортой байх нэг шалтгааныг тухайн жилд гангийн болон коксын үйлдвэрүүд зээлийн хатуу горимд ажилласан тул нүүрсний овоолго нь багассан тул оны сүүлд спот зах зээлээс нүүрс илүү их худалдан авч зузаатгал хийсэн тул нүүрсний үнэ огцом буурахгүй байхад хүргэсэн.

Австрали Хятадруу коксжих нүүрс түлхүү нийлүүлдэг ба хоёр улс чөлөөт худалдааны тухайд олон жил хэлэлцсэний эцэст 11-р сарын 17-нд тохироонд хүрсэн бол 2015 онд албан ёсоор чөлөөт худалдааны гэрээ байгуулсан өдрийн маргааш нь коксжих нүүрсний импортын 3 хувийн татвараа Австралийн нүүрсэнд цуцалсан байна.

Нүүрсний чанарын удирдлага

Хятадын засгийн газар байгаль орчны бохирдлын асуудал хурцаар тавигдсан энэ цаг мөчид нүүрсний чанарын босгыг хатуу болгож хяналтаа чангатгасан юм. Хятадын Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо 2014 оны 9-р сард хүхэр болон үнслэг ихтэй чанаргүй импортын болон дотоодын нүүрс арилжааланд 2015 оны 1-р сарын 1-нээс эхлэн хориг тавина гэж зарласан байна. Импортын металлургийн нүүрсний үнслэгийн агууламж дээд талдаа 40 хувь, хүхрийн агууламж 3 хувь, фосфорын агууламж 0.15 хувь байхаар тогтоосон байна. Харин Хятадын боомтоос гангийн үйлдвэр хүрэхэд холын тээвэр буюу 600 километрээс дээш зам туулах нүүрсэнд тавих шаардлага илүү өндөр буюу үнслэг нь 30 хувь, хүхэр нь дээд талдаа 2 хувь байх юм. Steel First мэдээгээр зах зээлд оролцогчид голдуу үнслэг нь 12 хувь, хүхэр нь 1 хувь, фосфор нь 0.1 хувиас хэтрэхгүй нүүрс импортлодог тул энэхүү арга хэмжээнд санаа зовохгүй

байгаа боловч бусад дайвар элементийн бүтцийн талаар засгийн газар шаардлага хүргүүлсэн нь тодорхойгүй байдал үүсгээд байна. Жишээ нь мөнгөн усны (mercury) агууламж 0.6µg/g, хүнцэл (arsenic) 80µg/g, хлор (chlorine) 0.3% ба фтор (fluorine) 200µg/g гэсэн үзүүлэлтээс босгоос доогуур байх шаардлага тавьжээ. Харин зарим гангийн үйлдвэрүүд нь худалдан авах нүүрсэндээ эдгээр элементийн сорилыг урд өмнө нь хийж байгаагүй бөгөөд үзүүлэлт нь шалгуурыг давах эсэхийг мэдэхгүй байгаа бол зарим үйлдвэрийн нүүрсний сорил нь хязгаарт тун ойрхон үзүүлэлттэй байгаа аж. Харин хилийн хяналт шалгалтын албад энэхүү хяналтаа хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгаа аж. Учир нь зарим алба нь нүүрсний агууламжид дайвар элементийн сорил хийх тоног төхөөрөмжгүй юм. Хятадын мэргэжлийн хяналт шалгалтын алба (CIQ) усан онгоц ачаагаа буулгасан өдрөөс 15 хоногийн дотор сорилыг гүйцэтгэнэ гэжээ. Сорил дуустал ачааг тээвэрлэх боломжгүй юм байна.

Нөөцийн татвар

2014 оны 12-р сарын 1-нээс эхлэн Хятад дотоодын нүүрсний нөөц ашигласны татвараа үйлдвэрлэсэн хэмжээнд бус харин борлуулсан хэмжээнд оногдуулахаар болсон байна. Энэхүү татварын шинэчлэлийн чухал хэсэг нь нүүрс олборлогчдын төлдөг байсан төрөл бүрийн татварыг цуцалсан явдал байлаа. Уламжилж ирсэнээр Хятадын нүүрс олборлогчид төрөл бүрийн татвар төлөхөөс гадна янз бүрийн төлбөр төлж ирсэн юм. Үүнд нүүрсний үнийн зөрүүг хаах сан, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх төлбөр, байгалийн нөөц ашигласны нөхөн төлбөр зэрэг багтдаг байна. Татварын шинэ дүрмийн дагуу орон нутгийн олборлогчийн зардлын дарамтыг бууруулах зорилгоор орон нутгийн засгийн газар нь татварын хувь хэмжээг 2-10 хувьд тогтоох юм. Харин засгийн газрын төрөл бүрийн санд төвлөрүүлэх төлбөр эсвэл засаг захиргааны хураамжийг шинээр үүсгэхгүй юм байна.

Шанси муж татварын хэмжээг 8 хувь гэж тогтоосон ба өмнө нь боловсруулаагүй нүүрснээс авдаг байсан 8 ам. долларын шимтгэлээ цуцалсан байна. Тэгэхлээр шинэ татварын журмын дагуу татварын хувь хэмжээ өссөн, нөгөө талд зарим хураамж болон нөхөн төлбөрүүд цуцалсан дүнгээр аль нь илүү нөлөө үзүүлэх нь одоогоор тодорхойгүй байна хэмээн нүүрс олборлогч мэдээлсэн байна. Хятад улс коксжих нүүрсний хэрэглээний арван хувийг импортоор хангадаг бөгөөд

дотоодын нүүрсний үнэ хэд байх нь олон улсын нүүрсний үнэд өрсөлдөгч утгаар нөлөөлдөг байна.

Экспортын татвар

2014 оны 12-р сард Хятадын сангийн яамнаас коксжих болон эрчим хүчний нүүрсний экспортын татвараа 2015 оны 1-р сарын 1-нээс эхлэн одоогийн байгаа арван хувиас бууруулж 3 хувь болгоно гэж зарласан. Энэхүү арга хэмжээ нь дотоодын зах зээлд дээр бий болсон нүүрсний илүүдэлийг арилгах зорилготой юм. Гэхдээ олон улсын зах зээл мөн адил нүүрсний илүүдэлтэй байгаа бөгөөд татварыг бууруулснаар бусад улс нүүрс авах уу гэдэг асуудал байна. Жишээ нь 2013 оны 1-р сард коксын бүтээгдэхүүний экспортын татвараа 40 хувь байсныг цуцалсан явдал Хятадын коксын экспортыг хямд болгож Энэтхэгийн коксжих нүүрсний эрэлтийг дүүргэсэн байна. Нөгөөтэйгүүр Хятад "swing" буюу зах зээлд ороод эсвэл гараад байдаг тоглогч учир Хятадын нүүрсний нийлүүлэлт нь олон улсын зах зээлд цаг үеийн үзэгдэл маягаар хэрэгждэг тул байнга нүүрс худалдан авагч улс болох Япон болон Өмнөд Солонгосын хувьд тогтортой нийлүүлэлт нь илүү чухал учир Хятадын коксжих нүүрсний нийлүүлэлтийг богино хугацаанд өрсөлдөх чадваргүй гэж харна.

Коксжих нүүрсний эрэлт нийлүүлэлтийн байдал

Коксжих нүүрсний богино болон дунд хугацааны ирээдүй бүдэг бадаг байна. Хэрвээ Хятад 2013-2014 онд нүүрс худалдан авсан эрчээр нүүрс импортлохгүй болвол нүүрсний хэт илүүдэл үүсэх аж. Credit Lyonnais Securities Asia (CLSA) хэмээх хөрөнгө оруулалтын банкны таамгаар Хятад 2020 он гэхэд одоогийн импортын талаас бага нүүрс худалдан авна гэжээ.

Энэтхэг нүүрс худалдан авна

CLSA мэдээгээр 2018 гэхэд Энэтхэг коксжих нүүрсний хамгийн том импортлогч болно. 2013 оноос Хятад коксын экспортын 40 хувийн татвараа цуцалсан учир

Энэтхэгийн хувьд хямд кокс худалдан авах сонирхол нэмэгдсэн юм. Хятад нүүрсний экспортын татвараа арван хувь байсныг 3 хувь болгосон явдал экспортыг урамшуулна.

Японы хэрэглэгч

Японы худалдан авагчид урт хугацааны тогтвортой нийлүүлэгчийг хайдаг тул Хятадын бодлого ганц шөнийн дотор өөрчлөгддөг учир Хятадаас нүүрс худалдан авах тэр болгон сонирхолгүй аж.

Хятадын нүүрс худалдан авагчид зээлийн хүрэлцээ муутай

Хятадын гангийн үйлдвэрүүд болон коксын үйлдвэрүүд өнгөрсөн онд зээлийн асуудалтай тулгарчээ. Жишээ нь Хаиксин Ган нь зээлийн өрөө барагдуулж чадаагүй улмаар үйл ажиллагаагаа зогсоож хаалгаа барьсан байна. Коксжих нүүрсний эцсийн хэрэглэгчид зээлийн олдоц муу байгаа тул нүүрс урьдчилан худалдан авч чадахгүй байгаа юм байна. Жижиг хувийн үйлдвэрүүд нь хамгийн их эрсдэлд өртсөн бөгөөд эдгээр гангийн үйлдвэр хаагдах юм бол коксжих нүүрсний эрэлт улам буурах аж. Кокс болоод гангийн гарц их байгаа нөгөө талаас засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах санаачлага эхэлсэн тул коксжих нүүрсний эрэлт бага байх юм.

Хятадын коксын салбар

Хятадын коксын салбарт хүчин чадлын илүүдэл болоод байгаль орчин хамгалах зохицуулалт нэмэгдсэн асуудалтай тулгараад байна. Хятадад нийт 2200 коксын үйлдвэр нь жилдээ 600 сая тонн кокс гаргах хүчин чадалтай аж. 2013 онд Хятад нийт 476 сая тонн кокс үйлдвэрлэсэн нь 2012 онтой харьцуулахад 8 хувийн өсөлт юм. 2013 онд нийт 17 сая тонн хүчин чадал бүхий үйлдвэрүүдийг хаасан байна.

Нийлүүлэлтийн дарамт

Австралийн олборлогчид үнэ буугаад байгаа тул зардлаа бууруулах зорилгоор нийлүүлэлтээ улам нэмэгдүүлсээр байна. Жишээ нь БиЭчБи Биллитон 2014 онд металлургийн нүүрсний олборлолтоо өмнөх оны 41 сая тонноос өсгөж 42.5 сая тонн болгоно гэж төлөвлөсөн.

Урьд өмнө Хятадын эрэг хавийн хэрэглэгчид бага үнэтэй импортын нүүрс худалдан авдаг байсан бол өнгөрсөн онд Шанси мужийн олборлогчид нүүрсний гарцаа нэмэгдүүлэн үнээ буулгаж үнийн уян зөөлөн бодлого баримтласны үр дүнд импортын нүүрс өрсөлдөх чадвараа алджээ.

Хсоал компани үнэ бууж байгаа нөхцөлд хэдийгээр АНУ-аас тээвэрлэлт хийхэд бэрхшээлтэй байгаа ч Хятадын зах зээлээ орхихгүй гэжээ. Тус компани Европ болон Өмнөд Америкт нүүрс нийлүүлэхээс гадна металлургийн нүүрсний эрэлт нь өсөж байгаа Хятад болон Азийн зах зээлд нийлүүлэлтээ үргэлжлүүлэх юм байна. Хсоал 2014 онд Хятадруу 3-4 сая тонн нүүрс нийлүүлсэн бол 2012 онд 5-6 сая тонн нийлүүлжээ.

Канадын олборлогч Тек Тесурс Хятадын коксжих нүүрсний зах зээлийг тэтгэсэн хэвээр байна гэж мэдэгджээ. Канадын нүүрс нь 2013 онд Хятадын нүүрсний импортын 15 хувийг эзэлсэн байна. Харин 2010 он тус үзүүлэлт 2 хувь байжээ. Тек Тесурс нь дөрвөн төрлийн коксжих нүүрс Хятадруу нийлүүлдэг байна: Elkview Standard, Elkview 2, Premium and Standard.

Австралийн олборлогчид

Коксжих нүүрсний үнэ олон улсын зах зээлд өсөх шинж алга байна. Учир нь нүүрс олборлогчид өртөг багатай уурхайн үйл ажиллагааг өргөжүүлсэн байна. Харин ирэх онд олборлолтоо хасах юм байна. Тэгэхлээр олборлотын хэмжээ ахицтай хасагдахаас нааш нүүрсний илүүдэл байж коксжих нүүрсний үнэ олигтой өсөхгүй юм байна. Зах зээлд нүүрсний нийлүүлэлтийн илүүдэл үссэн гэдгийг оролцогч бүр мэдсэн хэдий ч хэн ч олборлолтоо хасах сонирхолгүй байгаа тул үнэ буурч байгаа. Зарим олборлогчид олборлолтоо бууруулна гэж зарласан ч энэхүү 20 сая тонн орчим хэмжээний нийлүүлэлт хасагдсаны үр нөлөө зөвхөн жилийн хоёрдугаарт хагаст мэдэгдэх аж. Учир нь уурхайн хаалт нь зөвхөн оны эцэст хүчин төгөлдөр болж

үйлдвэрлэл хаагдсан ч уурхай хуримтлагдсан овоолгоо тодорхой хугацаанд борлуулсан хэвээр байх юм. Үүний сацуу олборлогчид нэгж зардлаа бууруулах зорилгоор өртөг багатай уурхайн гарцаа нэмэгдүүлсэн байна. Ойрын зургаан сард олон улсын нүүрсний үнэ хэвийн байх бөгөөд хаа нэгэн газраас нүүрсний нийлүүлэлт буурсан цагт үнэ эргээд өсөх юм байна.

Олон улсын нүүрсний үнэ

2014 оны эхний гурван сард коксжих нүүрсний спот зах зээлийн үнэ 20 ам. доллараар буурч үүнээс хойшхи хугацаанд харьцангуй тогтвортой байв. 2014 оны гэрээт дундаж үнэ 126 ам. доллар болсон нь 2013 оны үнээс 21 хувиар буурсан үзүүлэлт юм. 2014 онд нийт 20 сая тонн бүхий нүүрсний үйл ажиллагаа хаагдсан бөгөөд 2015 онд уурхайн хаалт мөн үргэлжилэхээр байна. 2015 онд сайн чанарын хатуу коксжих нүүрсний үнэ 4.2 хувиар буурч дунджаар 120 ам. доллар (BREE) болох юм. Харин 2016 оноос Хятадын баруун болон төв бүсийг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажил өрнөх үед коксжих нүүрсний эрэлтийн өсөлтийг дагаад үнэ өсөж 130 ам. доллар болно.

Ашигласан материал

Bureau of Resources and Energy Economics (BREE), Resources and energy quarterly December Quarter 2014, Australian Government, Canberra, 2014, <http://www.bree.gov.au>

EIA (U.S. Energy Information Administration), coal statistics and analysis, US DOE/EIA, Washington DC, 2014 <http://www.eia.gov/coal/>

IEA (International Energy Agency), Coal Information 2014, OECD/IEA, Paris, 2014.

IEEJ (Institute of Energy Economics), Outlook for International Coal Market, July 11, 2014

Steel First, 2014 REVIEW: Chinese policies take seaborne coking coal market by surprise, 2014

KPMG, Metallurgical Coal Q4 2013 and Q1 2014, *Commodity Insights Bulletin*, 23 July 2014

World Coal Association, Coal Facts 2014, London, September 2014, www.worldcoal.org

World Steel Association (WSA), www.worldsteel.org